## АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2024/247/НА-СТА-ТЗШ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2024 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр
Утас: 99089114 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо
Утас: 88012671 Цахим хаяг: ichinkhorlooga@audit.gov.mn

Ари файнэнс аудит ХХК-ийн захирал Д.Ариунаа
Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/66
танай ________-ны № ________-т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН УЛААН-УУЛ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ Д.АМАРЖАРГАЛ ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

2023 онд хувьсах зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 668,315.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих 105.0 мянган төгрөг, нийт 668,420.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулж 91,598.9 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 38,500.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 623.6 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

### Аудитын гол асуудал

Аудитаар тайлант онд ажиллагсдын гарт олгох цалинг 159.3 мянган төгрөгөөр илүү олгож авлага үүсгэж ажилласан зөрчилд зөвлөмж өгсөн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй эдийн засгийн ангилал зөрчсөн 6,016.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлэхээр, тайлант онд гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлэгдээгүй багш нарт 4,898,6 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгосон зөрчилд төлбөрийн акт тогтоохоор шийдвэрлэсэн.

### Бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, 41 арга хэмжээний хүрээнд Улаан-Уул сумын Засаг даргатай гэрээ байгуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, 91.8 хувийн биелэлттэй үнэлүүлж ажилласан байна.

6724041102

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2024 оны 09 сарын 26 өдөр    № 28/A2270439/ХӨА-2024/247/НА-СТА-ТЗШ    Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны 12 дугаар сард тайлант онд гүйцэтгэлийн үнэлгээгээр үнэлгдээгүй нэр бүхий 8 багшид багш нарт үр дүнгийн урамшуулал 4,898,575 (*Дөрвөн сая найман зуун ерэн найман мянга таван зуун далан таван*) төгрөгийг илүү тооцож олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Тайлант оны 12 дугаар сард нэр бүхий 8 багшид илүү тооцон олгосон 4,898,575 (Дөрвөн сая найман зуун ерэн найман мянга таван зуун далан таван) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт[1] нотлох баримтын хамт ирүүлэхийг Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Амаржаргал, нягтлан бодогч Э.Оргилмаа нарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР    А.ЭРДЭНЭБААТАР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР    Л.ПУНСАЛ-ОРЛОМ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, 302, тоот Утас:70384043

6724020095

**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2024 оны 02 сарын 26 өдөр № 12/А2270439/ХӨА-2024/247/НА-СТА-ТШЗ Мөрөн сум

*Зөрчил арилгах тухай*

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 29,428,981.59 /Хорин есөн сая дөрвөн зуун хорин найман мянга есөн зуун наян нэгэн төгрөг тавин есөн мөнгө/ төгрөгийн 2 зөрчил илэрсэн. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 1 мэдээлэл буюу дараа жилийн төсвийн төслийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш зарлагын 4 гүйлгээний 23,412,150 төгрөгийн мэдээлэл мэдээлээгүй байна.
2. Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардал руу зардлын бүлэг хооронд 1,741,611.59 төгрөгийг гүйлгэн зарцуулсан, Бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчин байгууллагын эзэмшлийн автомашин байхгүй байж 4,275,220 төгрөгийн шатахуун зарцуулсан.

Дээрх зөрчил нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6 дугаар зүйлийн 6.1.3-т "дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд “Нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т “*Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.*”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т “Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлэх, зөрчлийг таслан зогсоох
2. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зөрчлийг таслан зогсоох;
3. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар[1]т нотлох баримтыг хамт ирүүлэхийг Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Д.Амаржаргал, нягтлан бодогч Э.Оргилмаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР Л.ПУНСАЛ-ОРЛОМ

[1] Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот

6724030042

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 116,640,194.59 | 182,176,629.47 |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 9,655,707.01 | 91,598,921.82 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 9,655,707.01 | 91,598,921.82 |
| 3121 | Төгрөг | 9,655,707.01 | 91,598,921.82 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 9,655,707.01 | 91,598,921.82 |
| 33 | АВЛАГА | 00.00 | 159,266.65 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 00.00 | 159,266.65 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 106,984,487.58 | 90,418,441.00 |
| 351 | Түүхий эд материал | 16,702,745.10 | 7,451,710.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,266,745.10 | 7,451,710.00 |
| 35130 | Эм боох материал | 2,436,000.00 | 00.00 |
| 354 | Хангамжийн материал | 90,281,742.48 | 82,966,731.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,509,500.00 | 00.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 65,042,582.50 | 49,831,280.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 7,277,809.98 | 14,909,421.00 |
| 35460 | Хүнсний материал | 13,451,850.00 | 18,226,030.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 158,509,102.22 | 146,818,727.06 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 158,509,102.22 | 146,818,727.06 |
| 392 | Биет хөрөнгө | 145,631,102.22 | 133,940,727.06 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 71,315,364.67 | 71,315,364.67 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -36,956,032.83 | -41,483,284.80 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 86,957,240.69 | 86,957,240.69 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -33,776,694.41 | -48,434,049.69 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 70,601,902.20 | 64,278,902.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -19,730,662.06 | -22,889,752.97 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 17,424,958.26 | 37,424,958.26 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -11,080,574.30 | -13,228,651.30 |
| 39217 | Ном | 875,600.00 | 00.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 12,878,000.00 | 12,878,000.00 |
| 39301 | Програм хангамж | 00.00 | 00.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 12,878,000.00 | 12,878,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 275,149,296.81 | 328,995,356.53 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 00.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 275,149,296.81 | 328,995,356.53 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 275,149,296.81 | 328,995,356.53 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 76,558,559.46 | 76,558,559.46 |
| 51101 | Өмч: - төрийн | 76,558,559.46 | 76,558,559.46 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 162,312,559.20 | 216,158,618.92 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 162,312,559.20 | 162,312,559.20 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 53,846,059.72 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 36,278,178.15 | 36,278,178.15 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 275,149,296.81 | 328,995,356.53 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 471,066,410.00 | 735,034,300.00 |
| 11 | ТАТВАРЫН ОРЛОГО | 00.00 | 00.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 21,111,110.00 | 28,218,500.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 21,111,110.00 | 28,218,500.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 105,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 105,000.00 |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Үндсэн хөрөнгө | 12,057,760.00 | 20,000,000.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого Бараа материал | 9,053,350.00 | 8,113,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 449,955,300.00 | 706,815,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 47,223,100.00 | 38,500,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,223,100.00 | 38,500,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 402,732,200.00 | 668,315,800.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 402,732,200.00 | 668,315,800.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 468,486,900.01 | 677,530,878.11 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 468,486,900.01 | 677,530,878.11 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 453,291,046.93 | 676,907,275.56 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 295,263,269.17 | 422,168,970.13 |
| 210101 | Үндсэн цалин | 228,528,928.99 | 290,594,877.42 |
| 210102 | Нэмэгдэл | 50,729,242.18 | 105,676,212.62 |
| 210104 | Урамшуулал | 16,005,098.00 | 25,897,880.09 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 36,854,963.15 | 53,695,948.41 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,094,147.15 | 36,836,894.41 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,945,076.00 | 4,214,714.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,356,062.00 | 3,371,830.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 569,527.00 | 842,983.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 5,890,151.00 | 8,429,527.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 15,935,356.12 | 26,846,545.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,983,309.28 | 1,526,397.45 |
| 210302 | Түлш, халаалт | 12,102,046.84 | 25,070,148.05 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,850,000.00 | 250,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 13,227,100.00 | 49,425,048.53 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,712,650.00 | 11,594,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,114,225.00 | 2,673,460.93 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 6,400,225.00 | 20,191,540.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 14,965,797.60 |
| 2105 | Нормативт зардал | 51,134,905.00 | 80,751,820.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 00.00 | 2,436,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 51,134,905.00 | 78,315,820.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,931,000.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,931,000.00 | 5,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 814,000.00 | 1,090,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 814,000.00 | 1,090,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 37,130,453.49 | 37,928,942.99 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,159,000.00 | 6,608,530.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,623,500.00 | 3,287,400.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 32,347,953.49 | 28,033,012.99 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,195,853.08 | 623,602.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,195,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,195,800.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 53.08 | 623,602.55 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 53.08 | 623,602.55 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 2,579,509.99 | 57,503,421.89 |
| 145 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН | 00.00 | 00.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 3,657,362.17 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 3,657,362.17 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -3,657,362.17 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 2,579,509.99 | 53,846,059.72 |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 63,680,559.46 | 300,250.00 | 46,354,679.14 | 110,335,488.60 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 63,680,559.46 | 300,250.00 | 46,354,679.14 | 110,335,488.60 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -2,956,256.28 | -2,956,256.28 |
| C08 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 76,558,559.46 | 36,278,178.15 | 162,312,559.20 | 275,149,296.81 |
| D01 | 2023 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл | 76,558,559.46 | 36,278,178.15 | 162,312,559.20 | 275,149,296.81 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 76,558,559.46 | 36,278,178.15 | 162,312,559.20 | 275,149,296.81 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 53,846,059.72 | 53,846,059.72 |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 76,558,559.46 | 36,278,178.15 | 216,158,618.92 | 328,995,356.53 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 449,955,300.00 | 706,920,800.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 00.00 | 105,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 00.00 | 105,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 105,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 105,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 449,955,300.00 | 706,815,800.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 47,223,100.00 | 38,500,000.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 47,223,100.00 | 38,500,000.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 402,732,200.00 | 668,315,800.00 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 402,732,200.00 | 668,315,800.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 440,299,591.79 | 624,977,585.19 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 440,299,591.79 | 624,977,585.19 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 425,103,738.71 | 624,353,982.64 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 293,055,338.71 | 420,586,625.19 |
| 210101 | Үндсэн цалин | 226,320,998.53 | 289,012,532.48 |

| | | | |
|---|---|---|---|
| 210102 | Нэмэгдэл | 50,729,242.18 | 105,676,212.62 |
| 210104 | Урамшуулал | 16,005,098.00 | 25,897,880.09 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 38,267,800.00 | 55,437,560.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,022,000.00 | 38,578,506.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,061,500.00 | 4,214,714.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,449,100.00 | 3,371,830.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 612,300.00 | 842,983.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,122,900.00 | 8,429,527.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 16,500,000.00 | 32,876,397.45 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,983,309.28 | 1,526,397.45 |
| 210302 | Түлш, халаалт | 12,666,690.72 | 31,100,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,850,000.00 | 250,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 48,498,800.00 | 83,090,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 48,498,800.00 | 83,090,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,930,200.00 | 5,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 6,930,200.00 | 5,000,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 814,000.00 | 1,090,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 814,000.00 | 1,090,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,037,600.00 | 26,273,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 18,037,600.00 | 22,984,300.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,000,000.00 | 3,289,100.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 15,195,853.08 | 623,602.55 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 15,195,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 15,195,800.00 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 53.08 | 623,602.55 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 53.08 | 623,602.55 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 9,655,708.21 | 81,943,214.81 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 9,655,708.21 | 81,943,214.81 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 9,655,707.01 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 9,655,708.21 | 91,598,921.82 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| № | ҮЗҮҮЛЭЛТ | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
|---|---|---|---|---|---|
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 9,655,707.01 | (9,655,707.01) | - |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 716,576,200.00 | 624,353,982.64 | 92,222,217.36 | 87.1 |
| 3 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 716,576,200.00 | 624,353,982.64 | 92,222,217.36 | 87.1 |
| 4 | Бараа, үйлчилгээний зардал | 716,576,200.00 | 624,353,982.64 | 92,222,217.36 | 87.1 |
| 5 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 501,865,500.00 | 420,586,625.19 | 81,278,874.81 | 83.8 |
| 6 | Үндсэн цалин | 328,628,000.00 | 289,012,532.48 | 39,615,467.52 | 87.9 |
| 7 | Нэмэгдэл | 154,476,400.00 | 105,676,212.62 | 48,800,187.38 | 68.4 |
| 9 | Урамшуулал | 18,761,100.00 | 25,897,880.09 | (7,136,780.09) | 138.0 |
| 11 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 62,734,200.00 | 55,437,560.00 | 7,296,640.00 | 88.4 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 12 | Тэтгэврийн даатгал | 42,658,700.00 | 38,578,506.00 | 4,080,194.00 | 90.4 |
| 13 | Тэтгэмжийн даатгал | 5,019,200.00 | 4,214,714.00 | 804,486.00 | 84.0 |
| 14 | ҮОМШӨ ний даатгал | 4,014,900.00 | 3,371,830.00 | 643,070.00 | 84.0 |
| 15 | Ажилгүйдлийн даатгал | 1,004,000.00 | 842,983.00 | 161,017.00 | 84.0 |
| 16 | Эрүүл мэндийн даатгал | 10,037,400.00 | 8,429,527.00 | 1,607,873.00 | 84.0 |
| 17 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 33,500,000.00 | 32,876,397.45 | 623,602.55 | 98.1 |
| 18 | Гэрэл цахилгаан | 6,150,000.00 | 1,526,397.45 | 4,623,602.55 | 24.8 |
| 19 | Түлш, халаалт | 25,000,000.00 | 31,100,000.00 | (6,100,000.00) | 124.4 |
| 20 | Цэвэр, бохир ус | 2,350,000.00 | 250,000.00 | 2,100,000.00 | 10.6 |
| 30 | Нормативт зардал | 86,106,200.00 | 83,090,000.00 | 3,016,200.00 | 96.5 |
| 32 | Хоол, хүнс | 86,106,200.00 | 83,090,000.00 | 3,016,200.00 | 96.5 |
| 34 | Эд хогшил худалдан авах | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 38 | Урсгал засвар | 5,000,000.00 | 5,000,000.00 | - | 100.0 |
| 43 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 1,096,400.00 | 1,090,000.00 | 6,400.00 | 99.4 |
| 49 | Мэдээллийн технологийн зардал | 1,096,400.00 | 1,090,000.00 | 6,400.00 | 99.4 |
| 53 | Бараа үйлчилгээний бусад зардал | 26,273,900.00 | 26,273,400.00 | 500.00 | 100.0 |
| 54 | Бараа үйлчилгээний бусад зардал | 22,984,800.00 | 22,984,300.00 | 500.00 | 100.0 |
| 55 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,289,100.00 | 3,289,100.00 | - | 100.0 |
| 97 | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 716,576,200.00 | 706,920,800.00 | 9,655,400.00 | 98.7 |
| 98 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 677,971,200.00 | 668,315,800.00 | 9,655,400.00 | 98.6 |
| 99 | Улсын төсвөөс санхүүжих | 677,971,200.00 | 668,315,800.00 | 9,655,400.00 | 98.6 |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 38,500,000.00 | 38,500,000.00 | - | 100.0 |
| 104 | Орон нутгийн төсвөөс | 38,500,000.00 | 38,500,000.00 | - | 100.0 |
| 110 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 105,000.00 | 105,000.00 | - | 100.0 |
| 112 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 105,000.00 | 105,000.00 | - | 100.0 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 9,655,707.01 | (9,655,707.01) | - |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 91,598,921.82 | (91,598,921.82) | - |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | - | - | - | - |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | - | - | - | - |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 22.00 | 22.00 | - | 100.0 |
| 134 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - | 100.0 |
| 135 | Гүйцэтгэх ажилтан | 11.00 | 11.00 | - | 100.0 |
| 136 | Үйлчлэх ажилтан | 10.00 | 10.00 | - | 100.0 |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 34,486.8 мянган төгрөгийн зөрчил[1] илэрснээс 4,898.6 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 29,429.0 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 159,3 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### *5.1. Залруулга*

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй.

### 5.2. Төлбөрийн акт

Тайлант онд байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр тухайн цэцэрлэг үнэлгдээгүй байж багш нарт үр дүнгийн урамшуулал 4,898,6 мянган төгрөгийг илүү бодож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3. Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 23,412.2 мянган төгрөгийн, зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 6,016.8 мянган төгрөгийн, нийт 29,429.0 мянган төгрөгийн 2 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 5.4. Зөвлөмж

***1. Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:***

Тайлант онд ажиллагсдын гарт олгох цалинг 159.3 мянган төгрөгөөр илүү олгож авлага үүсгэсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба “нийцсэн бөгөөд зохистой” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:** Өглөг, авлага үүсгэхгүй ажиллах

Дээрх акт, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 9 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | Буруу тусган илэрхийлсэн | Үүнээс | | Зөвлөмж |
|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулсан | Залруулаагүй | |

[1] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 | 0 |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | То о | Дүн | То о | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Батлагдсан төсвийг зориулалтаар нь зарцуулаагүй | 1 | 6,016.8 | 0 | 0 | 1 | 6,016.8 | 0 | 0 | | 0 | 0 | 0 |
| Өглөг, авлага үүсгэсэн | 1 | 159.3 | | | | | 1 | 159.3 | | | | |
| Үр дүнгийн урамшуулал илүү олгосон | 1 | 4,898.6 | 1 | 4,898.6 | | | | | | | | |
| ***Дүн*** | 3 | 11,074.7 | ***1*** | ***4,898.6*** | ***1*** | ***6,016.8*** | 1 | **159.3** | ***0*** | ***0*** | ***0*** | ***0*** |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Хугацаа хоцроож мэдээлсэн | 1 | 0 | 0 | 0 | 1 | 23,412.2 | | |
| Мэдээлээгүй | 4 | 23,412.2 | 0 | 0 | 0 | | | |
| | | | | | | | | |
| ***Дүн*** | ***5*** | ***23,412.2*** | ***0*** | ***0*** | ***1*** | 23,412.2 | | |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| | | | 0 | 0 | | | 0 | 0 |
| ***Дүн*** | | | | | | | ***0*** | ***0*** |
| ***Нийт дүн*** | ***5*** | ***23,412.2*** | ***0*** | ***0*** | ***1*** | 23,412.2 | | |

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО:

АХЛАХ АУДИТОР Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН

ЗАХИРАЛ ПАРТНЕР Д.АРИУНАА ОГНОО:

ГЭРЭЭТ АУДИТОР Л.ПУНСАЛ-ОРЛОМ ОГНОО: 2024.02.20

Аудитын код: ХӨА-2024/247/НА-СТА-ТЗШ 16